

1920-ИОД ОНЫ МОНГОЛ, ХЯТАДЫН ХАРИЛЦААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

С.Дамдинсүрэн*

1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын үр дүн болсон ардын эрхт засаг, Монгол Улсын тусгаар тогтнолыг баталгаажуулах гадаад чухал нөхцөлийн нэг бол Монгол, Хятадын харилцааг хэвийн болгох явдал байв. Хятад нь Монголыг өөрийн газар нутгийн нэгэн хэсэг хэмээн түүхийн болон олон улсын эрх зүйн ямарч үндэслэлгүй бодлого баримтлан, Зөвлөлт Орос, Монгол хоёр татгалзсан учир үйлчлэх чадавхиа алдсан гурван улсын гэрээ гэгчээс сууралдсаар байсан юм. Хятадын милитарист хүчин монголд цэрэг илгээж түүний тусгаар тогтнолыг устган өөртөө хүчээр нэгтгэх, Монголын Засгийн газар Хятадын милитаристуудын байнгын заналхийллийн эсрэг сэргийлэн хамгаалах арга хэмжээ авахын зэрэгцээгээр нэгэнт бодитой болж буй тусгаар тогтнолоо гадаад олон улсаар, түүний дотор Хятадаар хүлээн зөвшөөрүүлэхийн тулд шаргуу чармайлт тавьж байсан билээ. Хятад нь Монголын тусгаар тогтнолын сөрөг хүчин болж их гүрний жанжлах, түрэмгий бодлого баримталж байсан нөхцөлд хоёр улсын харилцаанд жуучлах үүрэг гүйцэтгэх хүсэлтийг ЗХУ-д хандаж Монголын Засгийн газар тавьжээ.

Монголын Ардын Засгийн газрын ерөнхий сайд бөгөөд Гадаад Яамны тэргүүн сайд Д.Бодоогос Зөвлөлт Оросын Гадаад хэргийн Ардын комиссар Г.З. Чичеринд илгээсэн 1921 оны есдүгээр сарын 10-ны нотод-"Монгол Улсын гадаад олон улстай эз найрамдал ба худалдааны гэрээ байгуулан, энгийн бат барилдлагыг илрүүлэн ёсоор явуулах хэрэгт хөндлөн этгээд болон жуучлан оролцож тусламж үзүүлнэ үү" гэхийн хамт Монгол, Хятадын хооронд найрамдлыг байгуулан хоёр улсын албан хэргийг харилцан нэвтрүүлэх явдал одоо хүртэл илрээгүй нь гэмшилтэй хэмээн тэмдэглээд энэ хэрэгт жуучлан туслах явдлыг зөвшөөрөн дараачлан хариу ирүүлэхийг хүсчээ.¹

Монгол Улс бүрэн эрхт тусгаар тогтносон улс болон оршин тогтнож, Хятадаас ямарч хамааралгүй болохоо дэлхийн олон улсад бас зарлан тунхагласан билээ. Монгол Улс тусгаар тогтносон тухай 1921 оны есдүгээр сарын 14-нд гадаад олон улсад тунхагласан бичигт: "Хятадын суверенитетыг дахин хүлээж хэрхэвч чадахгүй, гагцхүү одоогийн байгуулсан ардын эрхтэй хэмжээт засгийг өөрөө эзэрхэн явуулж, Дундат, Монгол эртнээс харилцан найрамдаж, худалдаа, арилжааг нэвтрүүлэн Дундат, Монголын хүн иргэнийг тус тусдаа энх түвшний улиралд хандуулахыг гүнээ эрмэлзэн" буйгаа дахин илэрхийлж, дэлхийн олон улсад мэдэгджээ. Энэхүү баримт бичигт Монголын автономит эрх хэмээгч нь амьдрах чадавхигүй жуурамч зүйл байсныг, улс төрийн мөн чанараараа хэрхэн үгүйсгэгдсэнийг бас илчилжээ. Түүнд өгүүлснээр Хятад нь Монголын Автономит эрхийг цэргийн хүчээр булаан эзэрхсэн, монголыг өөрийнхөө хэсэг гэж байнга зүтгэдэг атлаа Оросын Барон Унгерн халдаар ирсэнд монголын газар орон, хүн иргэний амь бие, эд хөрөнгийг батлан хамгаалж чадаагүй, тийм чадваргүй болохоо харуулсныг нотлон Монголыг өөртөө нэгтгэх гэсэн хятадын харгис хүчний санаархлыг эрс няцаасан юм.

МАХН-ын анхны баримт бичгүүдэд автономитыг сэргээх зорилго

* С.Дамдинсүрэн, ЗХАСТ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, түүхийн ухааны доктор

тавьж байсан бол хувьсгал ялж Ардын эрхт засаг төр тогтсны дараах шинэ нөхцөлд МАН болон Монголын Засгийн газар ийнхүү автономитаас эрс татгалзаж Монгол улсын бүрэн тусгаар тогтнолын байр сууринаас хандаж, ЗХУ-ын жуучлалд их найдлага тавьсан байна. Монголын Засгийн газрын байр суурийг дэмжиж Зөвлөлт Орос Улсын засгийн газраас ирүүлсэн хариу нотод: "Монголын ард түмний өөртөө засан тогтнох эрхийг хэрэгжүүлэхдээ, үүний нэгэн хамт Монгол, Хятадын найрамдалт, ажил хэрэгч харилцаа тогтоох нь чухал гэсэн монголын Ардын хувьсгалт Засгийн газрын тууштай үзлийг Оросын Засгийн газар бүрэн хуваалцан, энэ чиглэлээр хийж буй алхмуудаа ойрын үед таатай үр дүнд хүрнэ гэж найдаж байна"² хэмээн мэдэгдээд Оросын Засгийн газар Хятадын засгийн газартай энэ асуудлаар хэлэлцээр хийх саналыг удаа дараа тавьсан, ойрын үед байнгын холбоо барих бодолтой байгаа гэдгээ илэрхийлжээ.

Монголын Засгийн газар автономитоос татгалзаж улс орныхоо бүрэн тусгаар тогтносон байдлыг бататгах боломж бүхнийг алдалгүй, улс төр, дипломатын тууштай алхам хийсээр байв. 1921 оны арван нэгдүгээр сард Зөвлөлт Орос улсын засгийн газартай хэлэлцээр хийх үеэр хэлэлцээр хийх нэгэн этгээдийн хувьд Монгол бол Хятадаас тусгаар улс болсныг тайларлаж монгол Улс гэдэг нэрээ тууштай хамгаалсны үр дүнд автономит хэмээхийг баримт бичиг тусгуулаагүй билээ. Зөвлөлт Оросын удирдлагаас "Чөлөөт Монгол Улс Оросоор жуучлуулан Бүгд найрамдах Хятад Улстай ойрын үед хийх хэлэлцээ нь саад тотгорыг хурдан арилгахад хүргэх болно"³ гэж мэдэгдсэнийг Монголын тусгаар тогтнолыг дэмжсэн Зөвлөлтийн удирдлагын байр суурь гэж Монголын тал сэтгэл ханамжтай хүлээн авчээ. Монголын олон улсын эрх зүйн статусын тухай болон Монгол Хятадын харилцааны тухай асуудал тусгагдаагүй боловч 1921 оны арваннэгдүгээр сарын 5-нд байгуулсан Монгол-Оросын хэлэлцээр нь Монгол Улс Хятадаас бүрэн тусгаар тогтносныг баталгаажуулах нэг чухал алхам болов.

Монголын Засгийн газар энэ хэлэлцээрийн дараа Зөвлөлт Оросын жуучлах ажиллагаа үр дүнд хүрнэ гэдэгт үл эргэлзэн Зөвлөлт, Хятадын төлөөлөгчдийн уулзалт, яриа бүрийг анхааралтай ажиж байв. 1921 оны 12 дугаар сард Бээжинд очсон ЗСБНХОУ-ын анхны төлөөлөгч А.К.Пайкесын хөтөлбөрт монголын асуудал тодорхой байр эзэлж байсан явдал монголчуудын анхаарлыг зүй ёсоор татсан юм. Пайкест өгсөн удирдамжид Зөвлөлт Орос Улс Монгол оронд өөрийн цэргийг байлган 1921 оны 11 сарын тохиролцоонд хүрч нэгэнт олж авсан байр сууриа үл хөндөн. Гадаад монголын оршин тогтнох асуудлаар Хятадын талтай ярилцан аль аль талдаа хүлээн авч болохуйц хэлбэрийг олох, Монгол Оросын хэлэлцээрийн талаар дуугүй өнгөрөөх чиглэл өгчээ. Хэлэлцээр эхэлмэгц л Хятадын гадаад Яамны сайд Ян Хуэйцин Монголд Зөвлөлтийн цэрэг байгаа асуудлыг шууд тавьж эхэлсэн бөгөөд улмаар монголын засгийн газраас Хятадтай хэлэлцээ хийхэд жуучлах хүсэлтийг Зөвлөлт Засгийн газарт тавьсныг болон Гадаад Монгол Хятадын хоорондын харилцааг зохицуулахад Зөвлөлт Засгийн газар бэлэн байгааг илэрхийлсэн Зөвлөлтийн төлөөлөгчийн саналыг хүлээж авахгүй гэдгээ илэрхийлжээ. Тэр үед Хүрээ, Хиагтын ажил хэргийг хариуцан гүйцэтгэх Хятадын Гадаад яамны гишүүнээр томилогдоод байсан Ли Хэнчун А.К. Пайкестай хэлэлцээ хийх Хятадын талыг төлөөлж хэд хэдэн удаа уулзаж ярилцжээ. Бараг хагас жил шахам үргэлжилсэн хэлэлцээрт монголын асуудал улам зонхилох байр эзэлж төлөөлөгчийн ажлын үр дүнг тодорхойлох болтлоо лавширсан билээ. Москвагийн удирдамжийн дагуу Пайкес эхлээд Монгол-Оросын

хэлэлцээр гэгч зүйл байхгүй гэж сайн мэдэхгүй дүр үзүүлсэн боловч Хятадын тал уг хэлэлцээрийн эхийг үзүүлсэнд хүлээн зөвшөөрөхөөс аргагүй болжээ. 1922 оны 4 дүгээр сарын эхээр Читад суугаа (дараа нь Москвад суусан) төлсөний түшмэл Чень Зунсюнь "Зөвлөлт-Монголын найрамдлын гэрээ" гэгчийг байгуулсныг гэрчлэн баталж уг гэрээ монголыг бүрмөсөн тусгаар тогтнохыг зөвшөөрөх гэсэн сэтгэл хуйвалдаан гэж мэдээлсэн байжээ. Ингээд Пайкест Хятадын Засгийн газрын эрс эсэргүүцэлтэй тулгаран улмаар буцахад хүрсэн ажээ. Дундат Улсын Засгийн газрын 1922 оны 5 дугаар сарын 1-ний өдөр А.К.Пайкест гардуулсан эсэргүүцлийн бичигт Зөвлөлтөөс монголтой нууц гэрээ байгуулсан нь Хятадын талаар Оросын эзэнт улсын явуулж байсан бодлоготой адил юм. Монголтой гэрээ байгуулснаар Зөвлөлт Засгийн газар өмнөх тунхаглалынхаа төдийгүй шударга ёсны бүх зарчмыг хөсөрдүүлж байна хэмээн зэмлээд уг гэрээг хүлээн зөвшөөрч чадахгүй эрс эсэргүүцлээ илэрхийлж байна гэж мэдэгджээ.

1922 оны 7 дугаар сард Хятадад ирсэн Зөвлөлт Оросын шинэ дипломат төлөөлөгч А.А. Иоффе Монголын асуудлыг урьдах төлөөлөгчдийн адил бие даалган, монголын Засгийн газрын төлөөлөгчийг оролцуулан хэлэлцэх, шаардлагыг орхиж, түүнийг ерөнхий бага хурал дээр бусад асуудлын хамт авч үзэх нь зүйтэй гэсэн чиг баримталжээ. Ийнхүү Монголын асуудал бол ерөнхий гол асуудлын хүрээнд шийдэгдэх түүний бүрэлдэхүүн хэсгийн тухай асуудал мэтээр тавигдах байсан байна. "Монголоос татгалзах", "монголыг шилжүүлэн өгөх" санаагаа Иоффе дэлхийн хувьсгал, хятадын хувьсгалд тус хүргэх гэгчээр "үндэстний харьцангуй ойлголт байх ёстой гэдэг үндэслэлээр сэтгэж байв. Цаашдаа Зөвлөлт-Хятадын хэлэлцээрт Монголын асуудлыг гол болголгүй Хятадын суверентетийг хүлээн зөвшөөрөх, Монголоос цэргээ гаргахад ЗСБНХУ болон гэдгээ зарлах зэрэг байр суурь баримтлах саналыг тэрээр Москвад тавьсан нь зохих дэмжлэг олжээ.

Иоффегийн санал Хятадын сонирхолд нийцсэн нь зүйн хэрэг. Бээжингийн Засгийн газрын нэлээ нэр хүнд буурч, суларсан нь улам бүр илэрхий болж байсан тэр үед Иоффе өмнөд хятадад очиж Хятадын хувьсгалт хүчнийг дэмжих чиглэлээр ажиллан Сунь Ятсентай хэд хэдэн удаа уулзаж ярилцсан байна. Тэдгээр уулзалт ярианд Монголын асуудал нэг бус удаа хөндөгджээ. 1923 оны 1 дүгээр сарын 23-нд Сунь Ятсен Иоффетэй уулзаж ярилцахдаа: "Хятадын хамгийн том бөгөөд нэн тулгамдсан асуудал бол улс орныхоо бүрэн бүтэн биш байдлыг эцэс болгож, улс орныхоо бүрэн тусгаар тогтнолыг олж авах явдал юм. Гадаад монгол бол хятадын газар нутгийн нэг хэсэг бөгөөд хятадаас салж болохгүй юм. Зөвлөлт Орос Улс Хаант Оросын үед Хятадтай байгуулсан эрх тэгш биш бүх гэрээг цуцлах ёстой"⁴ гэжээ.

1923 оны 1 дүгээр сарын 26-нд нийтлэгдсэн Сунь Ятсен, Иоффе нарын нарын үсэг зурсан хамтарсан мэдэгдэлд: "Оросын Засгийн газар Гадаад Монголд эзлэн түрэмгийлэх бодлого явуулах буюу түүнийг Хятадаас тусгаарлах зорилго өгтхөн ч тавиагүй гэж ноён Иоффе хатуу мэдэгдсэнд доктор Сунь Ятсен сэтгэл бүрэн хангамжтай байна"⁵ гэжээ. Сунь Ятсен Зөвлөлт Холбоот Улсаас Хятадын хувьд явуулж буй бодлогыг сайшааж, Зөвлөлтийн цэргийг Гадаад Монголоос нэн даруй гаргах шаардлагагүй гэж үзсэн тухай мөн мэдэгдэлд өгүүлжээ.

Орос-Хятадын хэлэлцээрийг анхааралтай ажиг байсан Монголын удирдлага Монгол улсын тусгаар тогтнолд хохирол учруулах аливаа алхмаас сэргэжлүүлэхийн тулд уг хэлэлцээрийн явцад аль болохоор нааштай нөлөөлөх, засгийн газрынхаа байр суурийг илэрхийлэх, ойлгуулах гэж идэвхтэй

ажиллаж байв. Монголын гадаад яамны сайд Б.Цэрэндоржоос ЗОУ-ын бүрэн эрхт төлөөлөгч Н.М.Любарскийд* гардуулсан нэгэн нотод: "Ойрноос гадаадын олон сонин бичигт Зөвлөлийн засагт Орос улсын төлөөлөгч Бээжингийн газраа хүрч Монгол улсын өөртөө тогтносон хэргийг Хятадын Засгийн газар лугаа жуучлан хэлэлцэхэд урьдын 3 этгээдийн гэрээ бичгийг журамлан автономит эрхийг эдлүүлэхээр саналаа илтгэжээ" гэх зэргийн үгс буй. Энэ нь элдэвлэвч манай монгол улсад өөртөө эзэрхэх бүрэн эрхийг эдлүүлэхэд үл дурлах ба зөвлөлийн засагт Орос, ардын засагт Монгол 2 улсын Засгийн газар ба мөн 2 этгээдийн олон түмэн ардын хооронд завсардуулахыг хичээсэн зальхай этгээдийн дэмий зохион тараасан худал үгс магад мөн. Тийм хэмээвч энэ хэр манай Монголын ард олноор ихэд хэрдхийн шүүмжлэлдэж буй тул үүнийг эрхэм элчин сайд Танд мэдтүгэй хэмээн явуулаад олдвоос эл учрыг байцаан толилж уламжлан зохих газраа нэвтрүүлэн явуулж эл учрыг ийм бус хэмээх явдлыг сонин бичгүүдэд хэвлүүлэн тарааж олны сэжиглэлийг устган бас ч хэрхэн шийтгэсэн явдлыг хариу ирүүлэх ажаамуй"⁶ гэжээ.

Энэ нот А.А.Иоффегийн саналыг үнэн мөнөөр нь илчилсэн буйртай баримт бичиг байсан боловч Н.М.Любарский хариу нотдоо Иоффе хэлсэн хэмээн сонин бичигт өгүүлсэн нь сониныхоны санаагаараа зохиосон зүйл юм гэсэн хариу өгчээ.

Хятадтай хэлэлцээр хийх дараагийн төлөөлөгч Гадаад хэргийн ардын комиссарын орлогч Л.М.Карахан 1923 оны 9 дүгээр сард Бээжинд Хятадын Гадаад яамны сайд Ван Жентинтэй Монголын асуудлаар ярилцсан тухай мэдээллийг Зөвлөлтийн ГХАК-аас Москва дахь Монголын элчин төлөөлөгчийн газарт мөн сарын 12-нд өгчээ. Түүнд дурдсанаар Гадаад Монгол өөртөө эзэрхэх эрхийг Дундат Улсын хэмжээтэй эзэрхэх эрх лүгээ хамт хүлээн авахаар хэлэлцээ нээхийг зөвшөөрөх буйзаа хэмээн Карахан хэлсэн бөгөөд Хятадын сайд ч Дундат улс Монголд өөртөө эзэрхэх эрх өгөхийг зөвшөөрөх тухай өгүүлсэн. Мөн Дундат Монгол 2 улсын төлөөлөгчид Бээжин хотноо хуралдан хэлэлцээ хийх болсон ажээ. Монголд Оросын улаан цэрэг байгаа нөхцөлд тийм хурал хийх боломжгүй юм гэсэн Хятадын талын мэдэгдэлд Карахан уг асуудлыг Хятад, монголын хурал дээр хэлэлцэн шийдвээс зохино гэсэн хариу өгснийг Хятад хүлээн авсан гэж уг мэдээлэлд бас өгүүлжээ⁷. Үүний дараахан Зөвлөлтийн ГХАК-аас Монгол Оросын найрамдал урьдын хэвээр байна. Орос өөртөө эзэрхэх эрхийг хүлээн зөвшөөрүүлэхийг хүснэ. Монголоос цэргээ гаргах асуудлыг Монголын засгийн газарай нухацтай хэлэлцэнэ гэж Монголын засгийн газарт уламжилсан байна. Хятадын хэвлэлд мэдээлснээр бол Карахан Бээжинд ирмэгцээ Монгол нь зохих хэмжээний автономит эрхтэйгээр Хятадын суверенитетэд үлдвэл Монголын эрх ашиг илүү хамгаалагдана, Монгол нутгаас цагаантны довтолгоон гарахгүй байхыг Хятад улс баталгаатай болгосон цагт, Орос улс үлдсэн цэргээ Монголоос гаргахад бэлэн байгаа гэдгийг илэрхийлжээ.

Монголыг Хятадын бүрэлдэхүүнд автономит эрхтэй байлгах, Монголын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хязгаарлах аливаа оролдлогыг Монголын засгийн газар ямагт эрс эсэргүүцэн няцаасаар байсан билээ. Монгол улсын ерөнхий сайд Б.Цэрэндорж РОСТА-гийн сурвалжлагчтай хийсэн нэгэн ярилцлагадаа "Монгол улс автономит ёсонд юмуу бусдын эрхшээлд орох тухай яриа ерөөс байж болохгүй нь мэдээж. Ийнхүү хэл ярианы цаг аль хэдийнээ өнгөрсөн. Эдүүгийн бий болсон байдлаас гарч, дараа нь сонирхож буй бүх этгээдүүдэд нийцэх байдал тогтоох ганцхан зам бол Монгол улсыг хүлээн зөвшөөрөх явдал" мөн гэдгийг нотлон тайлбарлажээ. Монголын засгийн газарт тусгаар тогтнолын туйлын хөтөлбөрөө хамгаалахын сацуу наад захын

Любарский Николай Маркович. 1922-1923 онд Монголд ЗСБНХУ ба АДБНУ-ын бүрэн эрхт төлөөлөгч байв

ямар хөтөлбөр байна вэ гэсэн сурвалжлагчийн асуултанд тэрээр хариулахдаа: "Бидэнд тусгаар тогтнол гэсэн ганц л хөтөлбөр бий. Энэ хөтөлбөрөөс ухрана гэдэг бол байж болшгүй зүйл мөн бөгөөд ямар нэгэн зүйлээр өөрсдийгөө хязгаарлана гэдэг бол мөн л бүтэшгүй зүйл"⁸ гэж мэдэгдсэн нь Ардын Засгийн газрын анхнаасаа баримталсан байр суурь билээ.

Монголын Засгийн газраас 1923 оны 11 дүгээр сард Зөвлөлт Засгийн газарт илгээсэн мэдэгдэлд Караханы Хятадтай хийж буй хэлэлцээр, түүнийг тойрсон мэдээнүүдийн үнэн магадад эргэлзэж буйгаа илэрхийлэхийн хамт Монгол, Хятадын хэлэлцээр хийхэд тодорхой болзол тавьсан байв. Үүнд: "1. Манай Монгол Улсын бүрэн эрхтэй, тусгаар тогтносон улс болсныг зөвшөөрөн хүлээх. 2. Манай Монголын бүхий л хохирсон зүйлийг бүрнээ төлөн өгөх. 3. Дотоод чуулганы зэрэг Монгол овогтонд автономит эрх тус тус олгох 4. Орос улсын төлөөлөгчдийг хуралд гэрч болгон суулгаж хэлэлцэх 5. Мөнхүү хэлэлцээг Хүрээнд нээхийг зөвшөөрөх аваас манай ардын засгийн газраас даруй бүрэн эрх барих төлөөлөгч нарыг томилон хэлэлцээ нээхийг зөвшөөрнө"⁹ гэж шаарджээ. Зөвлөлтийн тал эдгээр саналыг үгүйсгээгүй боловч хэрэг дээрээ няцаасан билээ. Юуны өмнө Орос улс "4 сая Хятад лугаа найрамдахыг хүсэх нь маш чухал болохын дээр тэрхүү 5 саналыг баримталж эдүгээ Хятад лугаа хэлэлцээн нээх хэмээвээс, Хятад огт хүлээхгүй гэх" зэрэг хэд хэдэн учирлал бүхий мэдэгдлийг Зөвлөлтийн ГХАК Чичерин 1923 оны 11 дүгээр сарын 15-нд Монголын элчин Давааг хүлээн авахдаа хийсэн ажээ.

Энэхүү мэдэгдэлд Монголыг дүүрэн эрхтэй автономит болгох асуудлыг бүр 1921 онд удаа дараа ярьж тохирч байсан хэмээн сануулсан байв.

Орос, Хятадын хэлэлцээр эхэлсэн үеэс Монгол Улсын тусгаар тогтнол бүрэн эрхийг хязгаарлах хандлага янз бүрийн түвшинд, янз бүрийн хэлбэрээр илрэх болсонтой хөлбөгдүүлэн монголын засгийн газар өөрийн байр суурийг хэлбэрэлтгүй илэрхийлэн хамгаалсаар байсан боловч хүлээсэн үр дүн гарсангүй. 1924 оны 1 дүгээр сарын 17-нд Л.М.Карахан Хятадын Засгийн газрын өмнөөс хэлэлцээр хийж байсан Ван Жентинд гардуулсан нотод: "Монголын тухай асуудлыг бид хэрхэн үзэж байгаа нь тов тодорхой, үүнд бид Монголыг Хятадын хэсэг гэж үзэх бөгөөд Хятадын Засгийн газраас манай хил хязгаарын аюулгүй байдлыг сахиулах баталгаа өгсөн даруйд Хүрээндээ удаан цэргийн ангиудыг гаргахад бэлэн байна"¹⁰ гэж мэдэгджээ.

Яван явсаар Иоффегийн сэдсэн үзэл санаа Л.М.Караханы хэлэлцээний үндэс болсон нь үүнээс харагдана. Ийнхүү Зөвлөлтийн тал Монголын асуудлаар ноцтой буулт хийснээр Хятадтай тохиролцоонд хүрч 1924 оны 5 дугаар сарын 31-нд Бээжин хотноо баримт бичигт гарын үсэг зурсны дотор "ЗСБНХУ ба Бүгд Найрамдах Хятад Улсын хоорондын асуудлыг зохицуулах ерөнхий зарчмуудын тухай хэлэлцээр" гэдэгт Монголын статусыг тодорхойлжээ. Энэхүү баримт бичгийн 5-р зүйлд: ЗСБНХУ гадаад Монголыг Бүгд Найрамдах Хятад улсын бүрэлдэхүүн хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд Монгол нутагт Хятадын бүрэн эрхийг хүндэтгэнэ" гэсэн байв. Үүний хамт Л.М.Карахан Зөвлөлтийн цэргийг Монголоос тохиролцсон хугацаанд гаргахад бэлэн байгаа тухай албан ёсны мэдэгдэл хийжээ.¹¹ Гэрээний энэ заалт агуулгаараа Монголын үндэсний ардчилсан хувьсгалын үр дүнд байлдан олсон тусгаар тогтнол, бүрэн эрхийг үгүйсгэсний хувьд 1915 оны гурван этгээдийн хэлэлцээр, автономиос ч ухарсан алхам хийснийг харуулав Монголын Удирдлагад хандахдаа Зөвлөлтийн тал автономитыг хүлээн зөвшөөрөхийг хэлэлцээрийн урьд хойно, удаа дараа сануулж, өөрийгөө зөвшөөрүүлэхийн тулд Зөвлөлтийн хийсэн аргагүй буулт байсан. Монгол-Зөвлөлтийн хэлэлцээр өөрчлөгдөхгүй хэвээр мөрдөгдөнө гэдгийг учирлан Монголд ажиллах өөрийн бүрэн эрхт төлөөлөгч А.Н.

Васильев, П.М. Никифоров зэрэг хүмүүст энэ талаар тухай бүр зааварчлан анхааруулж байжээ. Тэд ч Монголын удирдлагад автономийн тухай тохиолдол бүрд ярих нь олонтоо болов. ЗСБНХУ-ын АК-ын зөвлөлийн дарга Т.Рыков Роста-гийн сурвалжлагчтай ярилцахдаа "ЗХУ ДИУ-ын бүрэн эрхийг хүлээн зөвшөрсөн нь монголыг даруй хүчээр үг дуугүй Хятадын бүрэлдэхүүнд оруулна гэсэн хэрэг огт биш гэдэг нь аяндаа мэдээжийн хэрэг. Хамгаас түрүүнд монголын ард түмний хүсэл зориг мэдэх ёстой"* гэсэн. Энэ бүхнээс үзэхэд Монголын Засгийн газар өөрийн тусгаар тогтнолын байр суурин дээр тууштай зогсоход Оросын талаас эсэргүүцэлтэй төдийлөн тулгарахгүй юм байна гэдэг илэрхий болов. Орос-Хятадын хэлэлцээрийн нэг зэрэг тал нь тэр үед Монголд шууд халдан довтлохоор бэлтгээд байсан хятадын милитаристуудын төлөвлөгөөг саатуулан зогсоосонд оршино

Зөвлөлт-Хятадын 1924 оны хэлэлцээр монголын ард түмний язгуур эрх ашиг, Монголыг олон улсын эрх зүйн субъект байх эрх, тусгаар тогтнолыг үгүйсгэсэн утга чанараараа монголчуудын зүй ёсны эсэргүүцэл төрүүлсэн юм. Орос-Хятадын хэлэлцээрийн явцад удаа дараа байр сууриа илэрхийлж байсан монголын нам, төрийн удирдлага юуны түрүүн улс орныхоо тусгаар тогтнолыг эрх зүйн үүднээс баталгаажуулах бие даасан алхам хийхээр шийджээ. Монголд бүгд найрамдах засгийг явуулах тухай Засгийн газраас өргөсөн саналыг намын Төв Хорооны бүгд хурлаар хэлэлцээд 1924 оны 6 дугаар сарын 7-нд гаргасан тогтоолд: "Богд хаан таалал төгссөн учраа, одоо ардын эрхтэй улсын ёсонд нийлүүлэн бүгд найрамдах засгийг явуулах тухай хэргийг хэлэлцээд бүгд найрамдах ард улсын засгийг явуулбаас зүйтэй болох ба, Да жунтан их ерөнхий даргыг сонгохгүй, улсын дээд эрхийг улсын их хурлын дүрмийн ёсоор тус хуралд хадгалж хурлын чөлөө цагт засгийн газраа хадгалах"-аар заажээ. Энэ шийдвэрийг ардын засгийн газар мөн сарын 13-нд гаргасан тогтоолоороо баталгаажуулаад хоёр их гүрний хэлэлцээрийн заалтыг үл хэрэгсэн тусгаар тогтносон бүрэн эрхт улсынхаа их хуралд бэлтгэх үндсэн хуулийг боловсруулах ажилд шуурхайлан орсон ажээ. 1924 оны 11 дүгээр сард хуралдсан улсын анхдугаар их хурал БНМАУ-ыг тунхаглаж, түүхэндээ анхны үндсэн хуулиа баталж, Монголын ард түмний байлдан олсон төрийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хуульчлан баталгаажуулж, түүхийн ямар ч сорилтыг туулах чадвартай ардчиллын зам дээр улс орноо гаргасан билээ. Орос Хятадын хэлэлцээрийн заалт нь 1919 оны Зөвлөлт-Оросын засгийн газрын тунхаглал, 1921 оны Монгол, Орос хоёрын гэрээнд харшилсан нь тодорхой учир Зөвлөлтийн тал Монголын эсэргүүцлийг няцаагаагүй төдийгүй, Бүгд Найрамдах Засаг тунхагласныг дэмжсэн юм. Үүний зэрэгцээ Зөвлөлт Холбоот Улс Хятадын хувьсгалыг дэмжих улс төр, дипломатын ангич зарчимд тулгуурласан нарийн бодлогыг боловсруулан явуулж дээрх хэлэлцээрийн заалтыг саармагжуулан Монголд өөрийн нөлөөг хүчтэй болгож, Хятадын нөлөөг үл нэвтрүүлэх шинэ шинэ арга замыг сүвэгчилсээр байв. Монголын Засгийн газрын урилгаар ирсэн Зөвлөлтийн улаан армийн ангиудыг Хятадын засгийн газартай тохиролцсоны дагуу гаргасан явдал бол ЗХУ Монголын талаарх Хятадын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрснөө ажил хэрэг дээр харуулсан нэг нотолгоо болж өгөв. Хятадын тал уг хэлэлцээрээр зургаан сарын дотор Гадаад Монголд Хятадын бүрэн эрхийг сэргээх асуудлыг боловсруулж дуусгахаар заасныг хэргжүүлэхийн тулд Дотоод Гадаад, Цэргийн зэрэг яамдын төлөөлөл бүхий комисс байгуулан ажиллахаар зэхэж байсан боловч дотоод дахь улс төрийн хямрал, цэргийн

* Уринская газета. 10 июня 1924 г

эрхтнүүдийн зөрчилдөөн, Хятадын 1925-1927 оны үндэсний хувьсгал, гадаад хүчин зүйлийн нөлөө зэргээс болж санаархалдаа хүрэх чадавхигүй байжээ. Үйл явдлын цаашдын хөгжил уг гэрээний заалт амьдралд хэрэгжих үндэсгүйг нотолж, Хятадад Монголыг түрэмгийлэн эзэгнэх ямар ч боломж олгоогүйн хамт, Монгол улс тусгаар тогтнон орших, хөгжин дэвжих замдаа орсон бодит байдлыг улам лавшруулан баталгаажуулах чиглэлээр хэлбэрэлтгүй өрнөсөн билээ.

Гэвч Хятадын засгийн газар, их гүрний үзэлтнүүд Монголыг эрхшээлдээ байлгахын тулд бололцоотой бүхий л арга саам хайсаар байсан юм. Бүр Зөвлөлт-Хятадын хэлэлцээр эхлэн явагдаж байсан тэр үеэс улс төр, суртал нэвтрүүлгийн болон зохион байгуулалтын зарим арга хэмжээг гүтгэлгийн янз бүрийн хэлбэртэй хослон хэрэгжүүлж байв Ялангуяа Богд хаан, Ванчин богд болон Монголчуудын дунд нэр нөлөө бүхий хүмүүсийг ашиглахыг ихэд оролдож байжээ.

Өвөр Монголын ван гүн нарын 1921 оны 7-р сард хуралдаж баталсан "Гадаад Монголын Засгийн эрх баригч хутагт лам, ван, гүн нарт" гэсэн захидлыг Монголын Засгийн газар 8-р сарын 5-нд хүлээн авсан байх бөгөөд түүнд монголыг Хятадын харъяанд автономит эрхтэй байхыг ятгаад Хятадтай найрамдлын хэлэлцээ хийх төлөөлөгч ирүүлэхийг санал болгожээ. Энэ саналыг Гадаад Монголын эрх баригчид хүлээн аваагүй бөгөөд түүнээс хойш удалгүй Монголын Засгийн газар Зөвлөлт Оросын засгийн газарт хандан Монгол, Хятадын харилцаанд зуучлах үүрэг гүйцэтгэх хүсэлт тавьсан билээ. 1922 оны эхээр Өвөр монголын зарим чуулган дарга, ван, гүн нарын илгээлт бичиг бүхий төлөөлөгчид Нийслэл хүрээнд иржээ. Хятадын эрх баригчдын сайшаасан тэрхүү илгээлт бичигт: Монгол бол таван угсаа нийлсэн Дундад иргэн улсын гэр бүл, нэгэн шашин шүтлэгтэн атлаа Гадаад Монголын цөөн хэдэн хүн эндүүрч бусдын үгэнд хууртан Дундад улсаас салж дайсныг урин ирүүлснээр дайны хэлд хохирсон мэтээр өгүүлээд, гадаадтай холбогдох болон улсын хилийг сэргийлэх, амар түвшин хийгээд түгшүүрт холбогдох хэргүүдийг Дундат улсын засгийн газраас шийтгэнэ, засаглалын эрхийн хүрээнд Монголчууд өөрөө засахад оруулна хэмээн мэдэгджээ. Мөн энэ хэргийн зөвлөлдөн хэлэлцэх төлөөлөгч ирүүлэхийг дахин ятгасан аж.

Үүнийг тэр үед нээгдээд байсан улсын хурал хянан хэлэлцээд, Монгол улс бол бүрэн эрхтэй, тусгаар тогтносон, ардын засагтай улс мөнийг нотлоод, таван угсааны хэмээх нь тунхагийн төдий болсон, өмнөд муж, Төвд тусгаар тогтносоныг харгалзан Дундат улсын бүх ард түмэн лүгээ найрамдлыг зузаатгахыг эрхэмлэн Бээжин Монгол хоёрын хооронд жуучлан хэлэлцэхийг Орос улсын засгийн газраа хүссэнийг зөвшөөрсөн тул төлөөлөгч томилон илгээж хараахан зохилдохгүй гэсэн хариу бичиг илгээхээр тогтжээ.

Хятадын хэвлэлд Монголын тусгаар тогтнолыг няцаах гэсэн гүтгэлэгийн янз бүрийн материал олонтаа гарч байв. Тухайлбал Богд хаан Монголоос Оросын цэргийг буцааж, хятадын цэргийг ирүүлэн Монголыг хятадын нэг муж болгохыг хүссэн мэтээр мэдээлжээ. Түүнд няцаалт болгож 1922 оны 5-р сарын 23-нд буулгасан Богд хааны зарлигт; "Энэ болбоос огт худал цуу үг болой. Миний бие гагцхүү одоогийн байгуулсан ардын эрхтэй улсын засгийг үүрт батлан хамгаалахыг гол зорилт болгон бас ч Зөвлөлийн Засагт Орос улсын засгийн газраас Монгол хятадын хооронд жуучлан хэлэлцэж эртхэнээс найрамдлын гэрээ бичиг хэлэлцэн тогтоолгож хоёр этгээдийн хүмүүн иргэнийг амаржуулахыг гүнээ эрмэлзэн бүхийгээс өөр үгүй болох явдлыг дотоод, гадаадад нийтэд зарлан ухуулагтун"¹² гэжээ.

Монголын газар нутгийг Хятадын уугуул нутаг болгон хувиргахад чиглэсэн Хятадын бодлогын нэг илрэл бол Өвөр Монголын уламжлалт засаг захиргааны хуваарийг өөрчлөх, аймаг, хошуудыг тарааж муж, сянь болгон зохион

байгуулах ажил байжээ. Энэ нь хожим 1928 онд байгуулагдсан " Монгол-Төвдийн хороо" -ны үеэс нэлээд идэвхийлсэн байна. Тэр нь " Монголын төлөөлөгчдийн бүлгэм", "Монгол нутгийн улс төрийн хороо" гэх мэтийг зохион байгуулж түүндээ Гоминданыг дагагч монгол ноёдыг оруулах зэргээр салан тусгаарлагчдын хэсэг бүрдүүлэх, шашныг улс төрийн зорилгод ашиглах гэх мэт элдэв аргаар монголчуудын эсэргүүцлийг сааруулахыг чармайж байв. Чухам энэ зорилгын үүднээс монголчуудын дунд нэр нөлөө бүхий Банчин богдод " Улсыг хашин гийгүүлэгч дэлгэрэнгүй билэгт их багш" , Жанжаа хутагтад" Ариун ухаанаар туслан сургагч" цол тус тус өргөмжилөн улс төрийн ухуулан сэнхрүүлэх зорилгод өргөнөөр ашиглах болжээ.

Ийнхүү Хятадын эх баригчид Өвөр монголын хүчин зүйлийг монголчуудын өөртөө засан тохинох эрх, үндэсний эв нэгдлийн амин чухал эрх ашигт эрс харш бөгөөд Хятадад хүчээр хавсарган нэгтгэх бодлогоо хэрэгжүүлэх хэрэгсэл болгон хувиргахыг махран оролдож байсан бол Монголын Засгийн газар огт өөр байр сууринаас хандаж Хятадын түрэмгий харгис бодлогын мөн чанарыг илчлэн няцаах, Алсдаа МОНГОЛ овогтон нэгдэн нэгэн улс болох , давын өмнө байлдан олсон тусгаар тогтнолоо хамгаалан бэхжүүлэх, Өвөр монголын ард түмний эрх чөлөө олоход бүх талаар туслах чиг баримталсан билээ.

Монгол улсын тусгаар тогтнолын гол сөрөг хүч болж байсан Хятад улстай харилцахдаа сөргөлдөх байр сууринаас биш, харин эерэг нааштай бүх хүчин зүйл, бүх боломжийг алдахгүй байх үүднээс хандах нь чухал байв.

Иймээс ч Монголын засгийн газар Хятадтай засаг төрийн чиглэлээр харилцах оролдлогыг жуучлалаар дамжуулан хийхийн хамтад Хятадын хувьсгалт хөдөлгөөн , түүнд оролцогч дэвшилт хүчинтэй холбоо тогтоох хэрэгтэй хэмээн үзэж, энэ талаарх , нам, олон нийтийн байгууллагуудын санаачлагыг идэвхитэй дэмжсэн билээ.

Тэр үед Алс Дорнодод дэлхийн хувьгалын үзэл санааг дэлгэрүүлэх, империализмийн эсрэг нэгдсэн фронт байгуулах чиглэлээр Коминтернээс өрнүүлж байсан үйл ажиллагаа нь өөртөө ихээхэн хүч, боломж нөөцийг агуулж, улс орнуудын хил хягаараас хальсан өргөн хүрээнд идэвхтэй нөлөө үзүүлж байв.

Энэ хүрээнд л Монгол Хятадын дэвшилт, хувьсгалт хүчний харилцаа төлөвшин хөгжсөн түүхтэй. Бүр 1920 оны зун ОК/б/ Намын Төв Хорооны Сибирийн товчооны дэргэд байгуулагдсан дорно дахины улс түмний секц, түүний харьяанд бий болсон Хятадын, Монгол-Төвдийн, Японы, Солонгосын хэлтсүүдийн үйл ажиллагааны явцад Монгол-Хятадын болон бусад орны хувьсгалт, дэвшилт нам, бүлгүүдийн хооронд харилцаа хамтын ажиллагааны эхлэл тавигдав. 1921 оны нэгдүгээр сараас Дорно дахины улс түмний секцийн бааз дээр Коминтерний Алс Дорнодын нарийн бичгийн дарга нарын газрыг зохион байгуулж дээрх дөрвөн хэлтсийг бүрэлдэхүүнд нь оруулж Дорно дахины ард түмний анхдугаар их хурлыг бэлтгэн хуралдуулах үүрэг хүлээлгэв. Дорно дахины хувьсгалт, дэвшилт нам, хөдөлгөөнүүдийн үйл ажиллагаа, хамтын хүч чармайлтыг идэвхжүүлсний үр дүнд уг их хурлын бэлтгэл хангагдаж 1922 оны эхээр Москва-Петроградад хуралдсан юм. Энэ их хуралд Монголоос МАН ба МХЗЭ-ийн төлөөлөгч 14 хүн оролцжээ. Энэ хурлын үеэр Монгол, Хятадын дэвшилт хүчний төлөөлөгчид идэвхитэй хамтран ажиллажээ. Тус их хуралд КИГХ-ны дарга Г.Е.Зиновьевийн тавьсан "Олон улсын байдал ба Алс Дорнод" гэдэг илтгэлд: "Бүх Хятад орныг харийн империалист хүчин аанай эзэгнэсээр байхад Өмнөд Хятадын хувьсгалчдын хэн нэг нь ч гэсэн Монголын ард түмний санаа сэтгэлийг харгалзахгүйгээр Монголыг одоо Хятадад буцааж нэгтгэнэ гэж хоосон номлолоор шаардах

юм бол буруу гэхээр барахгүй асар их алдаа гаргана гэдгийг бид та нарт хэлэх ёстой. Асуудлыг тэгж шийдэх юм бол зөвхөн Монголд төдийгүй Хятадад өөрт нь хүнд дарамт болно. Учир юу вэ гэвэл бусад орныг ямар нэг хэмжээгээр дарлахыг оролддог эрх чөлөөтэй улс орон гэж байгаагүй билээ”¹³. гэж Монгол, Хятадын хувьсгалт хүчний харилцааны нэн чухал шаардлагыг тусган илэрхийлжээ. Тус их хуралд Монголын төлөөлөгчдөөс Ө.Дэндэв, Б.Данзан, С.Буяннэмэх нар илтгэл тавьж үг хэлж Дорно дахины ард түмний эв санааны нэгдлийн үзэл санааг бүрэн дэмжсэн байна. Их хурлаас Дорно дахины ард түмэнд хандаж гаргасан тунхагт Алс Дорнодод Холбооны улс байгуулах үзэл санааг дэвшүүлсэн бөгөөд түүнд Хятад, Япон, Солонгос, Индонезийнн төлөөлөгчдийн хамт Монголын төлөөлөгчид гарын үсгээ зуржээ. Дорно дахины үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг дэлхийн хувьсгалтай нэгэн урсгалд нийлүүлэх, империализмын эсрэг нэгдмэл фронтод нэгтгэх, Алс дорнодын холбооны улс байгуулах гэх зэрэг Коминтерний чиг шугам тэдгээр орны улс төрийн нам хүчнүүдийн үзэл баримтлал, улс төрийн бодлогыг үндсэнд нь тодорхойлж, хүчтэй нөлөөлсөн билээ. Иймээс ч Хятадад ардын хувьсгал ялсан нөхцөлд тэнд байгуулах холбооны улсын бүрэлдэхүүнд Монголыг оруулна гэсэн үзэл санаа ялангуяа Хятадын талаас байн байн сонсдох болов.

МАН Хятадын милитарист харгис хүчний эсрэг тэмцэгчид, хувьсгалт нам, хөдөлгөөнүүдтэй холбоо тогтооход онцгой анхаарч, бүр хувьсгалын өмнөх үеэс эхлэн Хятадын ард түмэн, түүний дэвшилт хүчинд урилга, захидал илгээх, янз бүрийн түвшинд төлөөлөгч солилцох зэрэг санал, санаачлага гаргаж байв. 1923 оны эцсээр МАН улс орныхоо байдлыг танилцуулах, Хятадын үнэн байдлыг мэдэх, Хятадын хувьсгалт, дэвшилт хүчинтэй холбоо тогтоох” зорилгоор өөрийн төлөөлөгч Б.Данзанг томилон илгээжээ. Тэрээр Гуанжоуд Сунь Ятсентэй, Бээжинд Гоминданы удирдах хүмүүс, Фын Юйсянтай тус тус уулзан холбоо тогтоож 1924 оны нэгдүгээр сард хуралдсан Гоминдан намын 1 дүгээр их хуралд оролцжээ. Сунь Ятсен, Б.Данзантай уулзахдаа “Бидний хоёр нам өмнө, умраас хөгжин мандаж дунд дор бүхий харгисуудыг устгаж, ард түмнийг гадаад дотоодын харгисуудын гараас эзэрхэг мэдлээс ангижруулж чадах буйг илтгэнэ. Үүнд хэн хэний үйлс бүрэн бүтнээр бүтэж, тус тус ард түмэн эрх чөлөөгөө олж үүрд энх түвшнээр аж төрж тус тус тогтнох болтугай”¹⁴ гэж хэлжээ. Энэ бол юуны өмнө Хятадын милитаристуудын аюул заналхийллийн эсрэг тэмцэлд эв санаа нэгтэй байж хамтран ажиллах талаар тохиролцсоныг харуулж байна. Гэвч Гоминдан намын баримт бичгүүдэд “Таван угсаа нэгдэх” тухай үзэл санаа, улмаар хятадад ардчилсан хувьсгал ялсан нөхцөлд Хятад-Монгол хоёр нэгэн холбоонд орох тухай олонтоо илэрхийлэгдэж байв.

1925 оны 4-р сард МАХН-ын төлөөлөгчид Бээжинд очиж Гоминданы төлөөлөгчидтэй нам хоорондын харилцааны асуудал хэлэлцэж 4 зүйл бүхий баримт бичиг боловсруулжээ. Тухайлбал : 1:Хоёр улсын ардын нам нь Сунь Ятсений үндэстэн өөрөө шийдвэрлэх, засан тохинох гэсэн гол зорилтыг баримтлан гүйцэтгэнэ. 2. Хоёр улсын ардын нам нь харилцан зорилтоо сурталчилна. 3. Хоёр улсын ардын нам нь харилцан төлөөлөгч томилно. 4. Хоёр улсын ардын нам нь хэрэг тохиолдвол харилцан туслалцана.”¹⁵ гэж 4 зүйлт гэрээ хэмээгдэх уг баримт бичигт өгүүлжээ. Үүний хамт ерөнхий сайдын орлогч А.Амар нарын хэлэлцэн тогтоосон 8 ба 10 зүйл хэмээх МАХН-ын архивт хадгалагдаж буй хятад хэл дээрх баримтад улс үндэстэн хоорондын харилцааны болон бага буурай үндэстэнд өөрөө засан тохинох эрх олгох зэрэг чухал асуудлыг тусгахын зэрэгцээгээр Фын Юйсяны армид цэргийн зэвсэг тээвэрлэн нэвтрүүлэх, адуу мал худалдан авахад туслах чиглэлтэй нэлээд өргөн асуудал хамарсан бололтой. 1925 оны 5 дугаар сарын 3-ны

өдөр хуралдсан МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн хурлаар Т.Рыскулов, Г.Гэлэгсэнгэ нарын Бээжинд очиж Гоминдан намын төлөөлөгчидтэй тус хоёр намын харилцааны зарчмын тухай асуудлаар ярилцсан тухай хэлэлцээд МАХН-ын Төв Хорооны дэргэд Гоминдан намын төлөөлөгч суулгахаар тогтсон байна. Үүний дараахан мөн оны 6 дугаар сард МАХН-аас Гоминданы Төв Хорооны дэргэд суух МАХН-ын төлөөлөгч Ц.Гүрсэд Бээжинд очихдоо дээрх 4 зүйлт гэрээний Монголын талын саналыг тусгасан хувилбарыг дахин хэлэлцээд урьд тогтсоныг үндсэнд нь зөвшөөрөлцжээ. Гэвч Гоминданы төлөөлөгчид Гадаад Монгол тусгаар тогтносон улс болохыг энэ удаа хүлээн зөвшөөрч болох авч "Хятадын хувьсгалын хэрэг төгссөн хойно Монгол лугаа найрамдаж бусдын нэгэн адил Холбоот улс болох" тухай өгүүллээр хаацайлан өнгөрөөж, уг гэрээ бичгийг батлагдсан хойно мөрдөхөөр тохиролцсон ажээ. Харин МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчдийн 1925 оны 25 дугаар хуралдаанаар уг гэрээг баталсан мэдээ бий.¹⁷

1925 оны 10 дугаар сард МАХН-ын Төв Хорооны дарга Ц.Дамбадорж Дотоод Монголын Ардын Хувьсгалт Намын их хуралд оролцох үеэр Фын Юйсянтай уулзсан, улмаар Бээжинд Коминтернийн төлөөлөгчтэй уулзахаар очих далимд мөн сарын 19-ний өдөр БНХАУ-ын ерөнхийлөгч Дуань Цижуйтай өөрийн хүсэлтээр уулзаж ярилцсан байна. Ерөнхийлөгч Монголыг Зөвлөлт Оросын нөлөөнд орж байна хэмээн түгшиж буйгаа илэрхийлэхэд нь Ц.Дамбадорж Монгол гурван улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байхад Хятад цэрэг эзэлснийг арилган хөөж, тэр цагаас хойш бүрэн эрх, тусгаар тогтнолоо найдвартай хамгаалж байгааг илэрхийлээд Октябрийн хувьсгалын дараа хуучин Оросын бодлого өөрчлөгдсөнийг цохон тэмдэглэжээ.¹⁸ МАХН-ын Төв архивт /Ц-4, I-д/ буй Ц.Дамбадоржийн тэмдэглэл зэрэг бусад материалаас үзэхэд тэр үеийн Монгол-Хятадын харилцааны талаар Хятад архивуудад судалгаа хийх шаардлага их байгааг дашрамд тэмдэглэе. БНХАУ ба Тайваны архивуудад судалгаа хийхгүйгээр монгол, хятадын харилцааны болон монголын түүхийн олон асуудлыг үнэн байдлаар нь тодруулахад учир дутагдалтай гэдгийг анхаарах цаг болжээ. 1926 оны 4 дүгээр сард Фын Юйсян Улаанбаатарт ирэхэд хоёр намын уулзалт болж түүнд монголын талаас Ц.Дамбадорж, Б.Цэрэндорж оролцсон юм. Энэ уулзалт, яриа монголыг хятадад хавсарган нэгтгэх үзэл болон "Монголыг Зөвлөлт Орос колоничилж буй" гэх мэт яриаг няцааж Монголын ололтыг өндөр үнэлсэн ажээ.¹⁹ Гоминданы төлөөлөгчид буцаж очоод монголын бодит байдлын талаар хятадын олон нийтэд зориулан тодорхой мэдээлэл нийтлүүлсэн тухай мэдээлсэн нь "Үнэн" сонинд бий.

1927 оны 4 дүгээр сард А.Амар, Ж.Гэлэгсэнгэ, В.Дорлигжав нарыг Гуандуны Засгийн газартай хэлэлцээр хийлгэхээр МАХН-ын Төв Хороо шийдвэрлэж байжээ.

МАХН, Гоминдан намын харилцаа нь нэлээд олон хэлбэрээр хөгжиж байсны дотор тус тусын Төв Хорооны дэргэд харилцан төлөөлөгч суулгах, Намын их хуралдаа төлөөлөгч урьж оролцуулах, намын удирдах зүтгэлтнүүд уулзалт хийх, захидал, бичгээр харилцах мэдээлэл солилцох, сурталчилгаа зохиох зэрэг ажил зохих үр нөлөөгөө үзүүлсэн билээ. Энэхүү харилцааны гол зорилго бол Монгол улсын тусгаар тогтнон оршиж буй бодит байдлыг Хятадын дэвшилт хүчинд үнэн мөнөөр нь танилцуулан дэмжүүлэх, монголыг хятадад хүчээр хавсарган нэгтгэх гэсэн милитарист бүлгийн санаархал, аливаа оролдлогыг таслан зогсоох, хятад дахь хувьсгалт хөдөлгөөний өрнөлтөд тус дөхөм үзүүлэх явдал гэж МАХН үзэж, түүнийг хөгжүүлэхийн төлөө их хүч чармайлт тавьж байв. Энэ нь Алс Дорнодын улс түмний үндэсний эрх чөлөөний төлөө тэмцлийн эрх ашигт нийцэж байна.

1925-1927 оны Хятадын хувьсгалыг дэмжих талаар Монголд өрнөсөн

олон талын үйл ажиллагаа Хятадын хувьсгалт фронтод нэгдсэн хүчнүүдтэй холбоо харилцаа хөгжүүлэх явдалтай хослож байсан бөгөөд Хятадын коммунист нам, дотоод Монголын ардын хувьсгалт намтай харилцах харилцаа ч энэ фронтын хүрээнд төлөвшиж байв. 1925, 1926 онд Хятадад очиж байсан МАХН-ын төлөөлөгчид ХКН-ыг үндэслэгчдийн нэг Ли Дажаотай нэг бус уулзаж байжээ. 1925 оны зун болсон нэгэн тийм уулзалт яриандаа: "Бид монголыг бүрэн эрхтэй, биеэ даасан улс хэмээн хүлээн зөвшөөрөхийг хүсч байна. Учир нь Монголчууд Хятадаас тусгаарлаад эрх чөлөөгөө хамгаалж чадсан төдийгүй империализмын эсрэг тэмцэлд хятад хүмүүс бидэнд, дэлхийн хувьсгалт хөдөлгөөнд их тус хүргэж байна"²⁰ гэжээ. МАХН-аас Гоминданы Төв Хороонд сууж байсан төлөөлөгч Ц.Гүрсэдийн илтгэх хуудсанд эв хамт намын гишүүн Ли Дажао нартай учран хоёр намын хооронд хэлхээ батыг үүсгэн хөгжүүлэх талаар ярилцсан тухай дурдсан буй. Мөн Гоминдан намтай тогтоох 4 зүйлт гэрээг боловсруулах, хэлэлцэхээд ХКН-ын төлөөгчид оролцож байжээ.

Хятадын эрх баригчдын байр суурь нэгэнт тодорхой харагдаж байсан нөхцөлд Өвөр Монголын ард түмний өөрөө засан тогтнох эрх, биеэ даах эрмэлзлэлийг хүндэтгэх асуудлыг төр засгийн түвшинд эс боловч нам, олон нийтийн харилцааны түвшинд ч хүлээн зөвшөөрүүлэх нь чухал гэж МАХН үзжээ. МАХН-ын Их хурлуудын болон бусад баримт бичигт энэ асуудал тодорхой тусгагдаж, хоёр талын удирдах зүтгэлтэн, төлөөлөгчдийн яриа хэлэлцээний үеэр олонтоо хөндөгдөж байв. А.Амар нарын 1925 онд Фын Юйсян болон Гоминданы төлөөлөгчидтэй хэлэлцсэн гэрээний төслийн 2-р зүйлд "Фын жанжин үндэсний зэрэг шийдэх эрхийг хүндэтгэн Өвөр Монгол зэрэг улсын дээрхи бага буурай үндэстэнд бүрэн тусалж өөртөө засах эрхийг олгоно"²¹ гэсэн томъёололыг оруулахаар санал болгосон ажээ.

Өвөр Монголд өрнөж буй үндэсний ардчилсан чиглэл бүхий тэмцэл хөдөлгөөнийг дэмжих, дэвшилт улс төрийн хүчнүүд үүсэн бүрэлдэх, үйл ажиллагаагаа нэгтгэхэд нь аливаа дөхөм үзүүлэн туслах, Монголын хувьсгалын мөн чанар, ач холбогдол МАХН-ын бодлогын утга санааг тайлбарлан таниулах, хятадын болон Алс дорнодын хувьсгалт хүчнүүдтэй үйл ажиллагаагаа уялдуулахад МАХН-ын гол анхаарал чиглэж байв.

Энэхүү ажлын явцад өвөр монголын хувьсгалт дэвшилт үзэлтэй хүмүүстэй холбоо тогтоож улмаар Дотоод монголын ардын хувьсгалт намыг байгуулахад бодитой тус хүргэсэн Монголын хувьсгалын үзэл санаа, зорилгыг ойлгон дэмжигч Барга, Өвөр Монголын ардчилсан үзэлтэй хүмүүс, тухайлбал, Мэрсээ, Булдэлгэр зэрэг хувьсгалчид 1922, 1923 онуудад Нийслэл хүрээнд удаа дараа хүрэлцэн ирснээсээ эхлэн Монголын удирдах хүмүүстэй байнга уулзаж, намын их, Төв Хорооны бүгд хуралд оролцох, нам, улс төрийн үйл ажиллагааны туршлагатай танилцах зэргээр ажиллаж байв. Барга, Өвөр Монголын хувьсгалт хөдөлгөөний удирдагчид нутаг орондоо хувьсгалт хөдөлгөөнийг өрнүүлэн улмаар Гадаад Монголтой нэгдэх хүсэлтээ нэг бус удаа илэрхийлж, тусламж дэмжлэг хүсч байжээ.

1922 онд Хөлөнбуйрт байгуулагдсан "Монголын залуучуудын нам"-ыг 1924 онд Дорнод хязгаарын Ардын хувьсгалт нам болгон зохион байгуулсаныг дэмжиж МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1924 оны 23-р хурал тэрхүү намд хүсэлтийнх нь дагуу чиглэл, зөвлөгөө өгч байхаар тогтжээ. Намын ажлыг дотоод Монголд дэлгэрүүлэх зорилгоор ДХАХН-ыг Дотосд Монголын Ардын Хувьсгалт Нам /ДМАХН/ болгон өргөтгөн байгуулах гэсэн санаачилгыг МАХН идэвхтэй дэмжиж, түүний дүрэм, эрмэлзэх зүйлийг боловсруулах комиссыг Төв Хорооныхоо дэргэд байгуулах /Тэргүүлэгчдийн 1925 оны 6-р сарын 6-ны хурлаар/, ДМАХН-ын их хурлыг бэлтгэхэд туслуулах зорилгоор намын туршлагатай ажилтнаа томилон илгээх, хөрөнгө санхүүгийн тусламж

үзүүлэх зэргээр улс төр, үзэл суртал, аж ахуйн олон талт үйл ажиллагаа явуулсан билээ. ДМАХН-ын I их хурлын бэлтгэл ажилд туслах анхны төлөөлөгч нь С.Буяннэмэх байв. Долоннуурт хуралдсан ДМАХН-ын I их хуралд МАХН-ын Төв Хорооны дарга Ц.Дамбадорж оролцож, улмаар тус намд туслалцаа үзүүлэхийн тулд Бээжинд очиж Коминтерний төлөөлөгчтэй уулзаж байсан ажээ. ДМАХН-ын олон ажилтныг Улаанбаатарын намын сургууль, цэргийн сургуулиудад бэлтгэн өгч байв.

МАХН ийнхүү ДМАХН-ыг дэмжихдээ монгол угсаатны бүхэл бүтэн байдал, монголчуудын эв нэгдлийн үзэл санааг удирдлага болгож Хятадын Гоминдан нам ХКН-аас жичид нь үзэж тэдгээрээс үл хамаарах харьцангуй бие даасан байдалтай байлгах бодлого баримталж байсан боловч аажимдаа түүнийг Хятадын ард түмний хувьсгалт тэмцлийг дэмжих тактик, дэлхийн хувьсгалыг өрнүүлэх Коминтерний ангич чиг шугамын үүднээс хандах хэрэгтэй болсон билээ.

Ийнхүү хориод оныг Монгол, Хятадын харилцаа нийгэм, улс төр, үзэл санааны болон дэлхийн хувьсгалын хүчин зүйлийн нөлөөн дор оршиж тус тусын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхөд хэтдээ зайлшгүй хүргэх үр хөврөлөө хуримтлуулж байжээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. "Уриа" 1921.8.18 Хуудас 4
2. Советско-монгольские отношения. Сборник документов. М.1921. 1966, с-11/
3. РЦХИДНИ ф.495, оп 152.д.9, л.17
4. Б.Лхамсүрэн "Монголын гадаад орчин төрийн тусгаар тогтнол", УБ.1995.42 дэх талд
5. Сун Хуэйдан "Миний өвөг эцэг Сунь Ятсен" Тайбэй, 1995, П боть, 173 дахь тал
6. Монголын гадаад харилцааны төв архив. ф.1. ХН.84
7. Монголын улсын түүхийн төв архив, ф.1, ХН.89
8. "Ардын эрх" сонин, 1992.10. 10-20
9. "Ардын эрх" сонин, 1924.8.27
10. Л.Дэндэв Монголын товч түүх УБ., 1934, 11 дэх тал
11. Советско-китайские отношения 1917-1957, Сборник документов. М., 1959, с.83
12. Монгол улсын түүхийн төв архив ф.1. .26, хн.2
13. Первый съезд революционных организация Дальнего Востока" Петроград, 1922, с.19-20
14. Ардын эрх. 1924.2.4.
15. Монгол Ардын Хувьсгалт Намын гуравдугаар их хурал, УБ , 1966.32 дахь тал.
16. МАХН-ын төв архив. Ц.7, Т.1 ХН 23.
17. "Ө.Бадрах" Намаас баруун бөөрөнхий лүгээ тэмцсэн амжилттай тэмцлийн туршлага" УБ., 1932 , 82 дахь талд.
18. МАХН-ын Төв архив Ц.4,д1, ХН.32, 33-34 дахь тал/
- 19 "Үнэн" сонин, 1926. он, №83.
- 20 МАХН-ын Төв архив, Ф,Т.2 ХН 176, Х-7
21. МАХН-ын төв архив Ц. 7, д.1 ХН 23.